



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Зорилт батлах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.10, 29.3 дахь хэсэг, Удирдлагын зөвлөлийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн аудитын байгууллагын 2022 оны зорилтыг “Аудитын чанарын хяналтын үр нөлөөг сайжруулах” гэж тодорхойлж баталсугай.

2. Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг “Аудитын чанарын хяналтын үр нөлөөг сайжруулах” зорилттой нийцүүлэн боловсруулж батлуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар (Б.Бундхорол)-т даалгасугай.

3. Дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр нэгжийн үйл ажиллагааг бусад нэгжийн үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулж, хамтран ажиллахыг Төрийн аудитын байгууллагын бүтцийн нэгжийн дарга/захирал, тэргүүлэх аудитор нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар (П.Цэрэнлхам)-т даалгасугай.



Д.ЗАНДАНБАТ